

**СЭЛЭНГЭ АЙМГИЙН САНХҮҮГИЙН ХЯНАЛТ
ДОТООД АУДИТЫН АЛБА**



ДОТООД АУДИТЫН АЖЛЫН ТАЙЛАН

**Аудитын нэр: САЙХАН СУМЫН “ГАВШГАЙ-УС” ААТҮГ-ЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ
ҮР ДҮН**

Аудитад хамрагдсан жил: 2023-2024

**АУДИТ ХИЙСЭН БАЙГУУЛЛАГА: СЭЛЭНГЭ АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН ДЭРГЭДЭХ
САНХҮҮГИЙН ХЯНАЛТ, ДОТООД АУДИТЫН АЛБА**

АУДИТ ХИЙГДСЭН БАЙГУУЛЛАГА: “ГАВШГАЙ-УС” ААТҮГ

АУДИТ ХИЙГДСЭН ОБЪЕКТ: “ГАВШГАЙ-УС” ААТҮГ

АУДИТЫН ТӨРӨЛ: ГҮЙЦЭТГЭЛИЙН

АУДИТЫГ ГҮЙЦЭТГЭХ ХУГАЦАА: 2024.06.10-2024.07.01

АУДИТАД ХАМРАГДСАН ХУГАЦАА: 2023-2024

Тайланг бэлтгэсэн:

**Дотоод аудитын нэгжийн
удирдлагын дарга**

Сэлэнгэ аймгийн Засаг даргын
дэргэдэх Санхүүгийн хяналт,
дотоод аудитын албаны дарга,
СХШУАБ Т.Одсүрэн

Аудитын багийн ахлагч :

Дотоод аудитор Г.Дорждэрэм

Аудитын багийн гишүүн:

Дотоод аудитор Х.Батбаатар,

Огноо:2024 оны 07 дугаар
сарын 01 өдөр

*Сүхбаатар сумын 2 дугаар баг.
Нутгийн удирдлагын II байр
sankhuu_audit_se@yahoo.com*

1. ТАНИЛЦУУЛГА

2. АУДИТЫН ЗОРИЛГО, ЦАР ХҮРЭЭ,

2.1.Аудитын зорилго

2.2 Аудитын цар хүрээ

2.3.Аудитын арга аргачлал, хязгаарлалт

3.БАЙГУУЛЛАГЫН САЙН ТУРШЛАГА

3.1 Засаглалын талаар

3.2 Эрсдэлийн удирдлагын талаар

3.3 Дотоод хяналтын талаар

4.АУДИТЫН ҮР ДҮН

4.1 Илэрсэн асуудлууд

5.НЭГДСЭН ДҮГНЭЛТ

1. ТАНИЛЦУУЛГА

Сэлэнгэ аймгийн Засаг даргын дэргэдэх Санхүүгийн хяналт, дотоод аудитын албаны 2024 оны нэгдсэн төлөвлөгөөнд тусгагдсаны дагуу Төсвийн тухай хуулийн 14 дүгээр зүйлийн 14.2.10¹, Төрийн хяналт шалгалтын тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.2.3² дахь хэсгийг үндэслэн аймгийн Засаг дарга бөгөөд Төсвийн Ерөнхийлөн Захирагчийн 2024 оны 06 дүгээр сарын 10-ны өдрийн 03 дугаар удирдамжийн хүрээнд Сэлэнгэ аймгийн Сайхан сумын “Гавшгай ус” аж ахуйн тооцоот үйлдвэрлэлийн газрын (цаашид Гавшгай-Ус ААТҮГ-гэх) үйл ажиллагаанд дотоод аудитыг хийж гүйцэтгэлээ.

Дотоод аудитыг Засгийн газрын 483 дугаар тогтоолоор баталсан “Дотоод аудитын дүрэм”-ийг тус тус үндэслэн санхүүгийн хяналт шалгалт, эрх зүйн нийцлийн чиглэлээр хийж хэрэгжүүлсэн ба 2023 – 2024 оны эхний хагас жилийн үйл явцыг хамруулан, дахин тооцоолох, тулган шалгах хяналтын горимыг ашиглах, холбогдох ажилтнуудтай ярилцах, дотоод хяналтын орчныг судлах, үнэлэх, ажил гүйлгээг батлах, хянах, бүртгэх, тайлагнах процессын эрсдэлийг үнэлэх, мөрдвөл зохих хууль тогтоомжийн зүйл, хэсэг, заалтын хэрэгжилтийн байдлыг бодитоор илэрхийлж тогтоох, зорилгод хүрсэн түвшин, хүлээн зөвшөөрөгдсөн байдал, практикт нийцэж байгаа байдлыг шалгуур үзүүлэлтээр тодорхойлж ажиллав.

2. АУДИТЫН ЗОРИЛГО, ЦАР ХҮРЭЭ

2.1 Аудитын зорилго:

"Гавшгай Ус" ААТҮГ-ын засаглал, эрсдэлийн удирдлага, дотоод хяналтын үйл явцуудын үр нөлөөтэй байдлыг үнэлж дүгнэх, тус байгууллагын үйл ажиллагааг сайжруулахад чиглэсэн зөвлөгөө өгөх замаар байгууллагын үнэ цэнийг нэмэгдүүлэх зорилготой.

2.2 Аудитын хамрах хүрээ, хязгаарлалт

"Гавшгай Ус" ААТҮГ-ын удирдлага зохион байгуулалтын засаглал, эрсдэлийн удирдлага болон дотоод хяналтын үйл явцыг үнэлэх;

Аудитаар тус газрын 2023 - 2024 оны эхний хагас жилийн үйл, ажиллагаа, төсөв, санхүү, өмч хөрөнгийн ашиглалт зарцуулалтыг хамруулна. Үүнд:

- ❖ *Байгууллагын засаглал, эрсдэлийн удирдлага болон дотоод хяналтын үйл явцыг үнэлэх;*
- ❖ *Эдийн засгийн үзүүлэлт, зорилтод түвшний төлөвлөгөө, гүйцэтгэлийн үр нөлөөг тооцох.*
- ❖ *Санхүү, төсөв, нягтлан бодох бүртгэл, холбогдох хууль тогтоомжууд, Засгийн газрын тогтоол шийдвэр болон түүнийг үндэслэн төрийн захиргааны төв байгууллагаас гаргасан заавар, журмын хэрэгжилт.*

- ❖ *Өр авлагын барагдуулалт, үүссэн өр авлагыг данс бүртгэлд бүрэн тусгасан эсэх.*
- ❖ *Дулааны шугамын хөрөнгө оруулалт, урсгал зардлын төлөвлөлт, гүйцэтгэлийн үр дүн*
- ❖ *Дулаан үйлдвэрлэх, ханган нийлүүлэх, өртөг, зардлын тооцоолол, үр нөлөөтэй байдал.*
- ❖ *Дулаанаар хангагч болон хэрэглэгчийн хооронд байгуулсан гэрээний хэрэгжилт.*
- ❖ *Нүүрсний худалдан авалт, зарцуулалтыг үр ашигтай байдал.*

Аудитын хамрах хүрээний хязгаарлалт:

“Гавшгай Ус” ААТҮГ-ын 2023-2024 оны үйл ажиллагааны хамрах хүрээнд хязгаарлалт байхгүй болно.

2.3 Аудитын арга, аргачлал

Дотоод аудитын мэргэжлийн практикийн Олон улсын стандарт, Засгийн газрын 2015 оны 483 дугаар тогтоолоор баталсан “Дотоод аудитын дүрэм”, Монгол улсын сангийн сайдын 2019 оны 12 дугаар сарын 23-ны өдрийн 268 дугаар тушаалаар батлагдсан “Улсын салбарын дотоод аудитын аргачлал”-ын дагуу үйл ажиллагааны эрсдэлийг үнэлэн албан тушаалтнаас асуулга тодруулга авах, нотлох зүйлсийг нягтлах, тулган баталгаажуулах, дүн шинжилгээ хийх горимуудыг ашиглав.

2.4. Аудитад ашигласан шалгуур үзүүлэлтүүд:

Аудитын зорилттой холбоотой дараах хууль, журам, дүрэм, зааврыг аудитын шалгуур үзүүлэлт болгон ашиглав. Үүнд:

- Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хууль
- Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хууль
- Авлигын эсрэг хууль
- Төсвийн тухай хууль
- Нийтийн албанд нийтийн болон хувийн ашиг сонирхлыг зохицуулах, ашиг сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлэх тухай хууль
- Хөдөлмөрийн тухай хууль
- Төрийн хэмнэлтийн тухай хууль
- Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль
- Татварын ерөнхий хууль
- Усны тухай хууль
- Эрчим хүчний тухай хууль
- Аймгийн ЭХЗЗ-ийн 2022 оны “Тарифт нэмэлт өөрчлөлт оруулах тухай” 19 дугаар тогтоол,
- Хот суурины ус хангамж, ариутгах татуургын ашиглалт үйлчилгээг зохицуулах зөвлөлийн 2021 оны 7 дугаар сарын 21-ний өдрийн “Сэлэнгэ аймгийн Сайхан сумын цэвэр, бохир усны үйлчилгээний тариф батлах” тухай тогтоол

- СТОУС, НББОУС болон бусад стандартууд
- “Гавшгай - Ус” ААТҮГ-ын дүрэм
- Бусад хууль, эрх зүйн актууд

2.5 Аудитын хугацаа, бүрэлдэхүүн

Дотоод аудитыг 2024 оны 06 дугаар сарын 10-ний өдрөөс 2024 оны 07 дугаар сарын 01-ний өдрийг хүртэлх хугацаанд Санхүүгийн хяналт, дотоод аудитын албаны дарга (Санхүүгийн хяналт шалгалтын улсын ахлах байцаагч) Т.Одсүрэн хянан удирдаж, аудитын багийн ахлагчаар Дотоод аудитор Г.Дорждэрэм, гишүүнд Дотоод аудитор Х.Батбаатар нар гүйцэтгэв.

3. Байгууллагын сайн туршлага

Мост финтек ХК-тай гэрээ байгуулснаар сар бүр аж ахуйн нэгж байгууллага болон оршин суугчдын гар утсанд цэвэр, бохир усны төлбөр төлөх мэдээллийг хүргэх үйлчилгээг нэвтрүүлсэн байна.

Сум орон нутгийн удирдлагууд болон аж ахуй нэгж байгууллагуудтайгаа хамтран ажилласны үр дүнд 2023 онд орон нутгийн төсвөөс 38.3 сая төгрөгийн хийн насосын хөрөнгө оруулалтыг шийдүүлсэн.

Байгууллагынхаа 40-н жилийн ойг угтаж ажиллагсдынхаа тав тухтай байдлыг хангах үүднээс захиргааны байр, өрөө тасалгаануудыг бүрэн засварлан шинэчилж, цех тасгуудын тохижилтыг хийж гүйцэтгэсэн.

Ажиллагсдын цалин хөлс цаг тухайдаа олгогдолгүй 2-3 сараар хоцорч олгогдож байсныг 2022 оноос хойш сар бүр тогтмол олгогддог болгон шийдвэрлэсэн. Энэ нь ажиллагсдыг тогтвор суурьшилтай ажиллах мөн залуу боловсон хүчнүүд нэмэгдэх зэрэг эерэг нөхцөлүүд бий болсон.

3.1 Засаглалын талаар

Сэлэнгэ аймгийн ИТХ-н 2005 оны 78 дугаар тогтоолоор “Гавшгай Ус” ХХК нэртэйгээр үйл ажиллагаа явуулж байсан бөгөөд аймгийн ИТХ-ын 2021 оны 09 дүгээр сарын 21-ний өдрийн 80 дугаар тогтоолоор “Гавшгай Ус” ААТҮГ болон өөрчлөгдсөн байна.

“Гавшгай Ус” ААТҮГ-ын захирлаар 2021 оны 10 дугаар сарын 01-ний өдрөөс Б.Үүрдмөнх томилогдон ажиллаж байна.

Тус байгууллагад төлөөлөн удирдах зөвлөл байхгүй болно.

“Гавшгай Ус” ААТҮГ-ын эрхэм зорилго: Хэрэглэгчдийг унд ахуйн стандарт, шаардлагад нийцсэн усаар хангах, хэрэглээнээс гарсан бохир усыг татан зайлуулж, байгаль экологид нөлөөлөлгүйгээр цэвэршүүлж ажиллахад оршино.

Дээрх зорилгын хүрээнд дараах үндсэн үйл ажиллагааг эрхэлж байна. Үүнд:

- Цэвэр усаар хангах /төвлөрсөн усан хангамж/
- Бохир ус татан зайлуулах /ариутгах татуурга/
- Зөөврийн усан хангамж /22 ус түгээх байр/
- Номгон тосгоны дулааны үйлчилгээ

Сэлэнгэ аймгийн Сайхан сумын 8000 гаруй, Номгон тосгоны 2000 гаруй оршин суугчид болон 20 гаруй төр төсвийн байгууллага, 110 орчим аж ахуй нэгжийг унд, ахуйн цэвэр усаар тасралтгүй хангах, ахуйн болон үйлдвэрийн бохир шингэнийг татан зайлуулах Номгон тосгоныг дулаанаар хангах ажлыг хариуцан ажилладаг тасралтгүй үйл ажиллагаа явуулж байгаа ААТҮГ юм.

Орхоноос Хөтөл рүү 3 өргөлт бүхий 3 насосын станцтай 18,9 км урт ус дамжуулах шугамтай, хоногт 6000 м³ ус олборлох хүчин чадалтай 3000 м³ бохир шингэнийг татан зайлуулж цэвэрлэх биологи цэвэрлэгээний байгууламж хотын доторх 12 км дулааны шугам сүлжээ, 9,4 км хэрэглээний усны шугам сүлжээ, Номгон тосгоны 5,8 км шугам сүлжээ 349 гаруй худаг камертай, 3200 м ашигтай талбай бүхий 29 ш 5 давхар орон сууцны барилгын сантехникийн систем, тоног төхөөрөмж, шугам хоолойн ашиглалтын засвар үйлчилгээг хариуцан хэвийн үйл ажиллагааг бүрэн хариуцан ажиллаж байна.

Тус байгууллага нь 24 цагийн тасралтгүй ажиллагаатай бөгөөд Хөтөл хотын ард иргэд, аж ахуйн нэгжийг унд ахуйн цэвэр усаар тасралтгүй, найдвартай хангах чиг үүрэг бүхий мэргэжлийн байгууллага юм.

Ашиглалтын алба, Засвар үйлчилгээний алба, Номгоны халаалтын төв, Захиргаа санхүүгийн алба гэсэн үйлдвэрлэлийн 4 үндсэн хэсэгтэй 80 гаруй ажилтан албан хаагчтайгаар үйл ажиллагаагаа явуулж байна.

3.2 Эрсдэлийн удирдлагын талаар

Тус газар нь эрсдэлийн удирдлагын бодлого, журам боловсруулаагүй, эрсдэлийн бүртгэл хөтлөөгүй байна. Байгууллагын эрсдэлийн үйл явцыг үнэлэхэд хүлээн зөвшөөрөх эрсдэл, эрсдэлийн мэдээллийг ашиглах зэрэг үнэлэх шалгууруудын түвшин бүрд байгууллагын эрсдэлийн удирдлагыг тодорхойлж үнэлээгүй байна.

Удирдлагын “ёс зүйтэй байдлыг дэмжин урамшуулах байдал”, ёс зүйгүй үйлдлийн эсрэг хандах хандлага, авах арга хэмжээ буруу, удирдлага шаардлага тавьсан ч үе шатны хяналтыг дутуу орхигдуулснаас хэрэгжилт нь хангалтгүй. Нөгөө талаар албан хаагчид итгэл алдаж албан тушаалын тодорхойлолтод заасан чиг үүргээ хэрэгжүүлээгүйгээс шалтгаалсан байна.

Байгууллагын эрсдэлийн удирдлагын төлөвшлийг тодорхойлоход эрсдэлийн соёл, эрсдэлийн засаглал, эрсдэлийн үйл явц эхлэлийн буюу 1-р түвшинд байна.

Иймд “Гавшгай Ус” ААТҮГ-ын даргад байгууллагын эрсдэлийг тодорхойлж, төлөвлөгөө боловсруулан, биелэлтийг цаг тухай бүрд тайлагнан хариу арга хэмжээ авч ажиллахыг зөвлөж байна.

3.3 Дотоод хяналтын системийн талаар

Засгийн газрын 2011 оны 311 дүгээр тогтоолын хавсралт “Аж ахуйн нэгж, байгууллагын үйл ажиллагаанд дотоод хяналт шалгалтыг Зохион байгуулах нийтлэг журам”, Орон нутгийн өмчит аж ахуйн тооцоот үйлдвэрийн газрын дүрэм,

Хөдөлмөрийн дотоод журамд дотоод хяналтын ажилтантай байна гэж тусгасан боловч дотоод хяналтын ажилтан томилон ажиллуулаагүй байна.

Иймд ААТҮГ-ын даргад байгууллагын дотоод хяналтын сул орон тоонд ажилтан томилон ажиллуулах, эс бөгөөс дотоод нөөц бололцоондоо тулгуурлан бусдаар хавсран гүйцэтгүүлэхийг зөвлөж байна.

4. АУДИТЫН ҮР ДҮН

4.1 “Байгууллагын засаглал, эрсдэлийн удирдлага болон дотоод хяналтын үйл явцыг үнэлэх” асуудлын хүрээнд:

<u>Илэрсэн асуудал 1</u>	Байгууллагын хэмжээнд эрсдэлийн аппетитийг тогтоогоогүй.
<u>Асуудлын ангилал</u>	Нөлөө ихтэй
Бодит байдал: Байгууллагын үйл ажиллагаанд учирч болох эрсдэлүүдийг үнэлэх, тодорхойлох албан тушаалтан байхгүй.	
Байх ёстой шаардлага /шалгуур/: Олон улсын мэргэжлийн практикийн стандарт 2120 “Дотоод аудитын үйл ажиллагаа нь эрсдэлийн удирдлагын үйл явцын үр дүнтэй байдлыг үнэлж түүнийг сайжруулахад хувь нэмрээ оруулах ёстой” Орон нутгийн өмчит аж ахуйн тооцоот үйлдвэрийн газрын дүрмийн 7 дугаар зүйлийн 7.1 дэх “Үндсэн үйл ажиллагааны болон санхүүгийн үйл ажиллагааг хянах дотоод хяналттай байна. Дотоод хяналтын бүтэц, ажиллах журмыг дарга батална”	
Асуудлын үндсэн шалтгаан: Байгууллагын удирдлага, албан хаагчид эрсдэлийн талаарх тодорхой ойлголтгүй, үйл ажиллагаанд дотоод хяналт, үнэлгээ хийдэггүй.	
Байгууллагад үзүүлэх нөлөө /үр дагавар/: Эрсдэлээ тодорхойлоогүй нөхцөлд байгууллага зорилгодоо хүрэхэд саад бэрхшээл тулгарах Байгууллагын үнэ цэнэ буурна, төсөв санхүүгийн хүндрэл учирч хэвийн үйл ажиллагаа алдагдана.	
Шийдвэр: Байгууллагын өдөр тутмын үйл ажиллагааг хэвийн явуулахад тохиолдох эрсдэлийг ангилан бүртгэж үнэлгээ хийх, эрсдэлийг бууруулах арга хэмжээний төлөвлөгөө, журам боловсруулж ажиллах зөвлөмж хүргүүлэхээр шийдвэрлэв.	

<u>Илэрсэн асуудал 2</u>	Байгууллагын дүрэм, хөдөлмөрийн дотоод журамд дотоод хяналтыг хэрэгжүүлэхээр тусгасан боловч дотоод хяналт хариуцсан ажилтангүй.
<u>Асуудлын ангилал</u>	Нөлөө ихтэй
Бодит байдал: “Гавшгай-Ус” ААТҮГ нь үйл ажиллагаандаа дотоод хяналтыг хэрэгжүүлээгүйгээс үйлдвэрлэлийн үйл ажиллагаа, гүйцэтгэх удирдлага, ажилтан албан хаагч нарт тавих хяналтын тогтолцоог хэрэгжүүлээгүй.	
Байх ёстой шаардлага /шалгуур/: Засгийн газрын 2011 оны 311 дүгээр тогтоолын хавсралтаар батлагдсан “Аж ахуй нэгж, байгууллагын үйл ажиллагаанд дотоод хяналтын шалгалтыг зохион байгуулах нийтлэг журам”-ын 1.3. Аж ахуйн нэгж, байгууллага нь энэхүү нийтлэг журамд нийцүүлэн, өөрийн үйл ажиллагааны онцлогт тохирсон “Дотоод хяналт шалгалтыг зохион байгуулах журам”-тай байна, 3.4. Дотоод хяналт шалгалтын нэгж, ажилтан нь тухайн аж ахуйн нэгж, байгууллагын үйл ажиллагааны онцлог, үйлдвэрлэл, үйлчилгээний чиглэл, хэмжээ, зохион байгуулалтын бүтэц, харьяалагдах нэгж, объектын тоог харгалзан тухайн жилд хийх хяналт шалгалтын ажлын тусгайлсан төлөвлөгөөг боловсруулан эрх бүхий албан тушаалтнаар батлуулан мөрдөж ажиллана. Орон нутгийн өмчит аж ахуйн тооцоот үйлдвэрийн газрын дүрмийн 7 дугаар зүйлийн 7.1 дэх “Үндсэн үйл ажиллагааны болон санхүүгийн үйл ажиллагааг хянах дотоод хяналттай байна. Дотоод хяналтын бүтэц, ажиллах журмыг дарга батална”, “Гавшгай Ус” ААТҮГ-н хөдөлмөрийн дотоод журмын 2.6, 2.12-т дотоод хяналтын ажилтны ажлын чиг үүргийг тусгасан боловч чиг үүргийг огт хэрэгжүүлээгүй байна.	
Асуудлын үндсэн шалтгаан: Дотоод хяналтын ажилтан сонгон шалгаруулан ажиллуулах нээлттэй зар удаа дараа явуулсан боловч ажил горилогч ирээгүй. Удирдлага санаачилга гарган дотоод нөөц бололцоогоо ашиглан хавсран гүйцэтгэх ажилтан томилоогүй.	
Байгууллагад үзүүлэх нөлөө /үр дагавар/: Удирдлага болон ажилтан албан тушаалтны хяналт уялдаа холбоо байхгүй, хяналт шалгалт хийгддэггүй.	
Шийдвэр: ААТҮГ-ын хөдөлмөрийн дотоод журамд заасны дагуу дотоод хяналтын ажилтан томилон ажиллуулж дотоод хяналтыг зохион байгуулж үр дүнг тооцон ажиллах зөвлөмж хүргүүлэхээр шийдвэрлэв.	

<u>Илэрсэн асуудал 3</u>	Байгууллагын бүтэц орон тоог ажлын байрны чиг үүрэгтэй уялдуулан шинэчлэн батлуулаагүй.
<u>Асуудлын ангилал</u>	Нөлөө дунд
Бодит байдал: “Гавшгай-Ус” ААТҮГ нь Сэлэнгэ аймгийн ИТХ-ын 2021 оны 09 дүгээр сарын 21-ний өдрийн 80 дугаар тогтоолоор орон нутгийн өмчит аж ахуйн тооцоот үйлдвэрийн газар болон өөрчлөгдсөн боловч байгууллагын орон тооны дээд хязгаарыг аймгийн Засаг даргаар батлуулаагүй.	
Байх ёстой шаардлага /шалгуур/: Аймгийн ИТХ-ын 2021 оны 09 дүгээр сарын 21-ний өдрийн 80 дугаар тогтоолоор баталсан байгууллагын Дотоод дүрэм 6 дугаар зүйл 6.2 дэх “Газрын бүтэц, зохион байгуулалт, орон тооны дээд хязгаарыг аймгийн Засаг дарга тогтооно”.	

<p>Асуудлын үндсэн шалтгаан: Орон тооны дээд хязгаарыг аймгийн Засаг даргаар батлуулаагүйгээс шалтгаалан одоо ажиллаж байгаа бүтэц орон тоо оновчтой байгаа эсэх.</p>
<p>Байгууллагад үзүүлэх нөлөө /үр дагавар/: Бүтэц орон тооны дээд хязгаарыг батлуулаагүйн улмаас үр ашиггүй орон тоонд цалингийн зардал төлөвлөснөөр санхүүгийн хувьд үр ашиггүй байх үндэс болно.</p>
<p>Шийдвэр: “Гавшгай-Ус” ААТҮГ -ын ажлын байрны чиг үүргийн нягтруулж бүтцийг оновчтой болгох замаар бүтэц, орон тооны дээд хязгаарыг аймгийн Засаг даргаар шинэчлэн батлуулж ажиллах зөвлөмж хүргүүлэхээр шийдвэрлэв.</p>

4.2 “Эдийн засгийн үзүүлэлт, зорилтод түвшний төлөвлөгөө, гүйцэтгэлийн үр нөлөөг тооцох” асуудлын хүрээнд:

Илэрсэн асуудал 4	Захирлын зөвлөлийг 2022 оны А/02 тушаалаар байгуулсан боловч ажиллах журмыг тушаалаар баталгаажуулаагүй
Асуудлын ангилал	Нөлөө их
<p>Бодит байдал: Захирлын зөвлөлийг 2022 оны А/02 тушаалаар байгуулсан боловч ажиллах журмыг тушаалаар баталгаажуулаагүй, зөвлөлийн хурлаар хэлэлцүүлсэн асуудал баримтаар нотлогдоогүй. Захирлын зөвлөл нь шаардлагатай тохиолдолд хуралдаж асуудлыг шийдвэрлэдэг гэх боловч хэлэлцсэн асуудал, авсан арга хэмжээний талаарх тэмдэглэл байхгүй. Ажлын төлөвлөгөө гүйцэтгэл байхгүй.</p>	
<p>Байх ёстой шаардлага /шалгуур/: Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.3-д "Захирал шаардлагатай мэргэжилтэн, албан тушаалтныг оролцуулан захирлын зөвлөл байгуулан ажиллуулж болох ба зөвлөлийн бүрэлдэхүүн, ажиллах журмыг захирлын тушаалаар батална.", Сэлэнгэ аймгийн Иргэдийн төлөөлөгчдийн хурлын 2021 оны 80 дугаар тогтоолоор баталсан Орон нутгийн өмчийн аж ахуйн тооцоот үйлдвэрийн газрын дүрмийн 6 дугаар зүйлийг тус тус зөрчсөн байна.</p>	
<p>Асуудлын үндсэн шалтгаан: Зөвлөл нь ААТҮГ-ын үйл ажиллагааны тайлан, бизнес төлөвлөгөөний төслийг хэрэгжүүлэхэд хяналт тавьж ажиллаагүй. ААТҮГ-ын дарга нь аймгийн Засаг даргатай байгуулсан үр дүнгийн гэрээ, Орон нутгийн өмчийн газартай байгуулсан гэрээ, түүний хэрэгжилтийг дүгнээгүй, ААТҮГ-ын тухайн жилд хийгдэх их засварын нэгдсэн төлөвлөгөө, төсвийг хэлэлцэж батлуулаагүй, үндсэн хөрөнгийн засвар үйлчилгээг хийх тооцоо судалгаа байхгүй,</p>	
<p>Байгууллагад үзүүлэх нөлөө /үр дагавар/: Байгууллагаас үзүүлж байгаа ажил, үйлчилгээ нь хууль, тогтоомж, дүрэм журам, эрх бүхий байгууллага, албан тушаалтны гаргасан шийдвэртэй нийцэхгүй байх, үйл ажиллагааны болон төсөв санхүүгийн эрсдэл үүссэн.</p>	
<p>Шийдвэр:</p>	

Цаашид Орон нутгийн өмчийн аж ахуйн тооцоот үйлдвэрийн газрын захирлын зөвлөлийг байгуулан болгон ажиллах **албан шаардлага** хүргүүлэхээр шийдвэрлэв.

4.3 Санхүү, төсөв, нягтлан бодох бүртгэл, холбогдох хууль тогтоомжууд, Засгийн газрын тогтоол шийдвэр болон түүнийг үндэслэн төрийн захиргааны төв байгууллагаас гаргасан заавар, журмын хэрэгжилт.

<u>Илэрсэн асуудал 5</u>	Анхан шатны баримтын бүрдэл хангаагүй 3,789.2 мянган төгрөгийг зарцуулсан байна.
Асуудлын ангилал	Нөлөө их
Бодит байдал: 2024 онд томилолтын хуудас, удирдамж, тайлан, унааны төлбөрийн баримтгүйгээр 3,552.0 мянган төгрөгийн томилолтын зардал олгосон, холбогдох албан тушаалтны шийдвэр, илүү цаг ажилласныг нотлох баримтгүйгээр 3 ажилтанд 237,2 мянган төгрөгийн илүү цагийн хөлс, нийт 3,789.2 мянган төгрөгийг анхан шатны баримтын бүрдэлгүйгээр олгосон байна.	
Байх ёстой шаардлага /шалгуур/: Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 13 дугаар зүйлийн 13.1 дэх "Анхан шатны баримт нь нягтлан бодох бүртгэл хөтлөх, санхүүгийн тайлан, мэдээллийг үнэн зөв гаргах үндэслэл болно", 13.7 дахь "Анхан шатны баримтын бүрдэлгүй ажил гүйлгээг бүртгэх, санхүүгийн тайланд тусгахыг хориглоно"	
Асуудлын үндсэн шалтгаан: Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, бодлогын баримт бичиг болон холбогдох дүрэм журмаа мөрдөж ажиллаагүй Байгууллагын нягтлан бодох бүртгэлд тавих хяналт сул байна Санхүүгийн үйл ажиллагааны ил тод байдлыг хангаж ажиллаагүй. Төрийн аудитын газраас өгсөн зөвлөмж, албан шаардлагыг хэрэгжүүлээгүй давтан гаргасан	
Байгууллагад үзүүлэх нөлөө /үр дагавар/: Төсөвт үр ашиггүй зардал үүсэх, хууль тогтоомж, дүрэм журмын хэрэгжилт хангагдахгүй байх	
Шийдвэр: Цаашид зайлшгүй шаардлагатай анхан шатны маягтуудыг өөрийн байгууллагын онцлогт тохируулан боловсруулж баталгаажуулан ашиглах. Анхан шатны баримтын бүрдэлгүй 3,789.2 мянган төгрөгийн зөрчилд төлбөрийн акт хүргүүлэхээр шийдвэрлэв.	

<u>Илэрсэн асуудал 6</u>	Ашиглах боломжгүй болсон элэгдлээ бүрэн нөхсөн үндсэн хөрөнгийн судалгаа, тооцоог гарган аймгийн ОНӨГ-т хүргүүлээгүй байна.
---------------------------------	---

<u>Асуудлын ангилал</u>	Нөлөө дунд
Бодит байдал: Газар дээр нь очиж тулган баталгаажуулахад ашиглалтын хугацаа дууссан, элэгдлээрээ өртгөө нөхсөн 4 нэр төрлийн 234 ширхэг, 266.348.3 мянган төгрөгийн үндсэн хөрөнгөөс цаашид ашиглах боломжтой хөрөнгийг үнэлж бүртгээгүй байна Мөн байгууллагын хашаанд 2,500.0 мянган төгрөгийн өртөг бүхий элэгдлээрээ өртгөө нөхөөгүй 3 дугуйт мотоцикл (2 ширхэг хөлдөөгч, 3 дугуйт мотоцикл, усны машин гэх мэт) хөрөнгүүд нь засаж, сэлбэх, ашиглах боломжгүй хөрөнгүүд бүртгэлтэй байна.	
Байх ёстой шаардлага /шалгуур/: Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.1.4 дэх “үнэн зөв байх”, 5.1.5 дах “хэмжигдэхүйц байх”, 20.2.4, Төрийн өмчийн бодлого зохицуулалтын газрын 2019 оны 271 дүгээр тогтоолын хавсралтаар батлагдсан журмын 7.1 дэх “Төрийн өмчит хуулийн этгээд нь эзэмшилдээ байгаа илүүдэл эд хөрөнгө болон элэгдэл хорогдлын шимтгэлээр анхны үнийг нөхсөн, түүнчлэн нөхөөгүй боловч гэмтэж засаж сэлбээд өөр зориулалтаар ашиглаж болох эд хөрөнгийн ашиглалтын хугацаа болон үнийг шинэчлэн тогтоох саналыг бэлтгэн Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газарт ирүүлж шийдвэрлүүлнэ” гэсний дагуу аймгийн Орон нутгийн өмчийн газарт саналаа хүргүүлж шийдвэрлүүлэх,	
Асуудлын үндсэн шалтгаан: Үндсэн хөрөнгийн тооллогыг зохих журмын дагуу хийж гүйцэтгээгүйн улмаас ашиглах боломжгүй хөрөнгүүдийн тооцоо судалгааг гаргаж орон нутгийн өмчийн газарт хүргүүлж шийдвэрлүүлээгүй байна.	
Байгууллагад үзүүлэх нөлөө /үр дагавар/: Дээрх хөрөнгө нь байгууллагын үндсэн хөрөнгийн дансны дүнг нэмэгдүүлж, бодит үнэ цэнийг бууруулж байна.	
Шийдвэр: Цаашид үндсэн хөрөнгийн дансанд бүртгэлтэй ашиглах боломжгүй, эдийн засгийн хувьд үр өгөөжгүй хөрөнгийн тооцоо судалгааг гарган, орон нутгийн өмчийн газарт санал хүргүүлэх зөвлөмж хүргүүлэхээр шийдвэрлэв	

<u>Илэрсэн асуудал 7</u>	Үндсэн хөрөнгийн ашиглалтын жилийн хугацааг НБББББ тусгасан элэгдэл тооцох хугацааг баримтлаагүйгээс 1,060.0 мянган төгрөгийн элэгдлийн зардлыг тайлант оны эхний хагас жилийн байдлаар илүү тооцсон
<u>Асуудлын ангилал</u>	Нөлөө их
Бодит байдал: <ul style="list-style-type: none"> • Үндсэн хөрөнгийн ашиглалтын аргаа буруу сонгосон, ашиглалтын хугацааг НБББББ-т тусгаснаас өөрөөр бүртгэсэн байна. Тухайлбал: Барилга байгууламжийг 18, 20-27, 31, 33, 39-43, 49, 55, 56 жил, Машин, тоног төхөөрөмж 1, 3, 5, 8, 10, 15, 38 жил, тавилга, эд хогшил, тоног төхөөрөмж 2 жил, компьютер, техник хэрэгсэл 1-3, 10 жил гэх мэтээр бүртгэсэн байна. • 2023 онд 5,199,223.7 мянган төгрөгийн үндсэн хөрөнгөнд 2,941,487.8 мянган төгрөгийн элэгдлийг байгуулсан ба өмнөх онд байгуулаагүй шалтгаанаар 2,614,929.2 мянган төгрөгөөр нэмж байгуулсан. 	

<ul style="list-style-type: none"> • Санхүүгийн программд нийт 105 ширхэг 1,713,925.0 мянган төгрөгийн хөрөнгийн ашиглалтын хугацааг жилийн 369 хоногоор тооцож элэгдлийн зардлыг 1,060.0 мянган төгрөгөөр илүү байгуулсан байна.
<p>Байх ёстой шаардлага /шалгуур/: Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичигт тусгасан үндсэн хөрөнгийн бүртгэлийн бодлого журмыг баримтлах хэсэгт “Барилга байгууламж 60 жил, Үйлдвэрлэлийн тоног төхөөрөмж, машин 10 жил, тавилга, эд хогшил, тоног төхөөрөмж 10 жил, компьютер, техник хэрэгсэл 3 жил”</p>
<p>Асуудлын үндсэн шалтгаан: Нягтлан бодох бүртгэлээр тавих хяналт сул, санхүүгийн программыг бүрэн ашиглаж сураагүй. Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичигт тусгасан үндсэн хөрөнгийн бүртгэлийн бодлого журмыг мөрдөж ажиллаагүй байна.</p>
<p>Байгууллагад үзүүлэх нөлөө /үр дагавар/: Элэгдэл хорогдол нь орлогын тайлан болон санхүүгийн тайланд нөлөөлж ашигт ажиллагаа, хөрөнгийн цэвэр үнэ цэнэ, санхүүгийн тайлан мэдээг буруу илэрхийлэхэд хүрнэ, элэгдлийн зардлыг буруу байгуулснаар татвар ногдох орлогод нөлөөлнө.</p>
<p>Шийдвэр: Цаашид Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичигт тусгасан үндсэн хөрөнгийн бүртгэлийн бодлого журмыг баримталж илүү тооцсон 1,060.0 мянган төгрөгийн элэгдлийн зардал, нийт хөрөнгийн ашиглалтын жилийг үнэн зөв бүртгэх албан шаардлага хүргүүлэхээр шийдвэрлэв.</p>

4.4 Өр авлагын барагдуулалт, үүссэн өр авлагыг данс бүртгэлд бүрэн тусгасан эсэх.

<u>Илэрсэн асуудал 8</u>	Он дамжсан 1,910,085.9 мянган төгрөгийн авлагыг барагдуулах талаар ойрын болон хэтийн төлөвлөгөө гарган ажиллаагүй
<u>Асуудлын ангилал</u>	Нөлөө их
<p>Бодит байдал:</p> <ol style="list-style-type: none"> 1. Дээрх он дамжсан 1,910,085.9 мянган төгрөгийн авлагыг хариуцагчаар нь ангилж үзвэл ажилчдаас авах 4,164.1 мянган төгрөг, иргэдээс /өмнө ажиллаж байсан/ 82,996.9 мянган төгрөг, аж ахуйн нэгж байгууллагаас 861,141.9 мянган төгрөг, оршин суугчдаас авах 961,783.0 мянган төгрөг байна. Дээрх авлагын 256,480.0 мянган төгрөгийг үлдэгдлийн баталгаагаар тооцоо нийлж, үлдэгдэл 1,653,605.9 мянган төгрөгийн авлагыг тооцоо нийлээгүй, насжилт өндөртэй, хариуцагч нь тодорхойгүй авлага байна. Үүнээс тооцоо нийлж баталгаажуулсан 30 аж ахуйн нэгжийн 236,203.2 мянган төгрөг, 28 иргэний 20,276.7 мянган төгрөг байна. 2. Нийт авлагын 11.4% буюу 217,553.2 мянган төгрөгийг хариуцагч тал хүлээн зөвшөөрдөггүй. 	
<p>Байх ёстой шаардлага /шалгуур/:</p> <ol style="list-style-type: none"> 1. Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.2.3-д "холбогдох олон улсын стандарт, эрх бүхий төрийн байгууллагаас баталсан нягтлан бодох бүртгэлийн стандарт, журам, заавар, энэ хуулийн 6 дугаар зүйлд заасан зарчмыг баримтлан нягтлан бодох бүртгэл хөтөлж, санхүүгийн тайлан гаргах", 20.2.5-д "дансны өглөг, авлага ба төлбөрийн тооцоог хянах", 20.2.6-д "...үлдэгдлийг баталгаажуулж, баримтжуулах ажлыг зохион байгуулах,..." гэсэн заалтуудыг зөрчсөн. 	
<p>Асуудлын үндсэн шалтгаан:</p>	

Тайлант онуудын санхүүгийн тайлан гаргах бүрд үйлчилгээний орлогын авлагын тооцоо нийлж баталгаажуулж, мэдэгдэх хуудас өгдөггүйгээс авлага ихсэх гол шалтгаан болсон.

Үйлдвэрийн газрын дарга, нягтлан бодогч нар солигдсон тухай бүрд авлагыг талаар хүлээлцэх актандаа тусгаагүй байна.

Байгууллагад үзүүлэх нөлөө /үр дагавар/:

Авлагыг барагдуулаагүйн улмаас үйлдвэрлэлийн үйл ажиллагааны зардлаа нөхөж санхүүгийн хувьд ашигтай ажиллах боломжгүй байна.

Шийдвэр:

Цаашид ажлын хэсэг байгуулан он дамжсан 1,910,085.9 мянган төгрөгийн авлагыг барагдуулах тусгайлсан төлөвлөгөө гаргаж ажиллах. Авлага барагдуулсан хэмжээгээр урамшуулал олгох системийг бий болгон ажиллах, /хуулийн зөвлөх гэрээгээр ажиллуулах/ **албан шаардлага** хүргүүлэхээр шийдвэрлэв.

4.5 Дулааны шугамын хөрөнгө оруулалт, урсгал зардлын төлөвлөлт, гүйцэтгэлийн үр дүн, дулаан үйлдвэрлэх, ханган нийлүүлэх, өртөг, зардлын тооцоолол, үр нөлөөтэй байдал

<u>Илэрсэн асуудал 9</u>	Номгон тосгоны халаалт дулааны асуудлыг 2008 оноос хойш хариуцаж байгаа бөгөөд 2018 оноос хойш санхүүгийн хувьд алдагдалтай ажиллаж байна.
<u>Асуудлын ангилал</u>	Нөлөө их
<p>Бодит байдал:</p> <p>Номгон тосгоны хаалтын төв нь төр төсвийн болон хувийн хэвшлийн 16 байгууллагыг дулаанаар хангадаг.</p> <p>2023 төвлөрүүлэхээр төлөвлөсөн орлого 169,096.1 мянган төгрөг үйлдвэрлэлд гарсан зардал 239,071.4 мянга төгрөг, 2024 оны эхний хагас жилийн байдлаар төвлөрүүлэхээр төлөвлөсөн орлого 123576.0 мянган төгрөг, үйлдвэрлэлд гарсан зардал 135,036.9 мянган төгрөг байна.</p> <p>2024 оны 1-5 сард 23,012.2 мянган төгрөгийн авлагатай байна. Номгон тосгоны дулаан үйлдвэрлэлийн үйл ажиллагаа нь санхүүгийн хувьд үр ашиггүй ажиллаж байна.</p> <p>Номгон тосгоны дулаан үйлдвэрлэлийг бусад сумдын дулаан үйлдвэрлэлтэй харьцуулахад үнэ тарифын хувьд ижил байгаа боловч алдагдалтай ажилладаг.</p>	
<p>Байх ёстой шаардлага /шалгуур/:</p> <p>Засгийн газрын 2020 оны 97 дугаар тогтоолын 2 дугаар хавсралт, Дулааны эрчим хүч хэрэглэх дүрмийн 8 дугаар зүйлийн 8.1 дэх. “Хангагч, хэрэглэгчийн хооронд хийх төлбөр тооцоог тоолуурын заалт (бусад тохиолдолд гэрээ)-ыг үндэслэн мөрдөж байгаа үнийн дагуу хийнэ”, 8.2 дах “Хэрэглэгчийн тоолуур гэмтэлтэй тохиолдолд төлбөр тооцоог зураг төслөөр тооцсон хүчин чадлыг үндэслэн (задгайгаар) хийнэ.”, 9 дүгээр зүйлийн 9.1.5 дах “хэрэглэсэн дулааны болон буцаагаагүй хувирсан усны төлбөрийг дараа сарын 10-ны дотор төлөөгүй”</p>	
<p>Асуудлын үндсэн шалтгаан:</p> <p>Дулаанаар хангаж байгаа байгууллагуудаас төлбөрөө бүрэн авч чаддаггүй, мөн дулаан үйлдвэрлэлийн гол түүхий эд нүүрсний үнэ өндөр байгаатай шууд холбоотой.</p>	

Байгууллагад үзүүлэх нөлөө /үр дагавар/: Үйл ажиллагааны төлөвлөлт буруугаас алдагдалтай төсөв батлаж дулаанаар хангаж байгаа нь алдагдалд нөлөөлж байна	
Шийдвэр: Дулаан үйлдвэрлэх төвийн тоног төхөөрөмж, үйл ажиллагаатай холбоотой тооцоо судалгааг хийж, орон нутгийн өмчийн газраар шийдвэрлүүлэх зөвлөмж хүргүүлэхээр шийдвэрлэв.	
<u>Илэрсэн асуудал 10</u>	Инженерийн шугам сүлжээ нь 40 жилийн насжилттай, ашиглаад 41 жил болсон. Дээрх хугацаанд бүрэн хэмжээний шугам сүлжээний их засвар хийгдээгүй.
Асуудлын ангилал	Нөлөө их
Бодит байдал: Тус газар нь Сайхан сумын газар доорх инженерийн шугам сүлжээг хариуцдаг. Инженерийн шугам сүлжээ нь 40 жилийн насжилттай, өнгөрсөн онд ОНСХ-р шугам сүлжээний 15%-д засвар хийсэн. “Хөтөл энерги” ХХК нь 12 км буюу 433,978.2 мянган төгрөгийн инженерийн шугам хоолойг түрээслэн сарын 33,000.0 мянган төгрөг төлбөр төлдөг боловч газар доорх дулааны шугам сүлжээ нь ашиглах хугацаа дуусаж шугам хоолойн эвдрэл гэмтэл их байгаагаас засвар үйлчилгээний зардалд уг орлого зарцуулагдаж байгаа томоохон эрсдэлийг дагуулж байна. Цаашид Аймгийн иргэдийн төлөөлөгчдийн хурлаар хэлэлцүүлж түрээслэгч байгууллагад шилжүүлэх тооцоо судалгааг гаргаж ажиллах шаардлагатай	
Байх ёстой шаардлага /шалгуур/: Засгийн газрын 2020 оны 97 дугаар тогтоолын 2 дугаар хавсралт, Дулааны эрчим хүч хэрэглэх дүрмийн 1 дүгээр зүйлийн 1.6 дах “Үйлдвэрлэгч, дамжуулагч, түгээгч, хангагч, хэрэглэгч нь өөрийн эзэмшлийн дулааны шугам сүлжээ, тоног төхөөрөмжийн ашиглалтыг бүрэн хариуцаж, үзлэг үйлчилгээ, засвар шинэчлэлийг өөрийн хөрөнгөөр мэргэжлийн байгууллага, ажилтнаар гүйцэтгүүлнэ.”	
Асуудлын үндсэн шалтгаан: Ашиглалтын хугацаа дуусаж элэгдэж муудсан газар доорх дулааны шугам сүлжээнд бүрэн хэмжээний шинэчлэлт хийх шаардлагатай. Шугам сүлжээний шинэчлэлтийн ажлыг ААТҮГ нь өөрийн санхүүгийн нөөц бололцоогоор хийх боломжгүй байна.	
Байгууллагад үзүүлэх нөлөө /үр дагавар/: Санхүүгийн хувьд үр ашиггүй үйлдвэрийн газрын ашигт ажиллагаанд сөргөөр нөлөөлж байна.	
Шийдвэр: Сайхан сумын газар доорх дулааны шугам сүлжээг тусгай зөвшөөрлийн дагуу үйл ажиллагаа явуулж байгаа “Хөтөл-энержи” ХХК-д зах зээлийн бодит үнийг судлан шилжүүлэх саналыг аймгийн ИТХ-д хүргүүлэх албан шаардлага хүргүүлэхээр шийдвэрлэв.	

4.6 Нүүрсний худалдан авалт, зарцуулалтыг үр ашигтай байдал.

<u>Илэрсэн асуудал 11</u>	Худалдан авах ажиллагааны журмыг баримтлаагүй, шууд худалдан авалт хийсэн байна.
----------------------------------	--

<u>Асуудлын ангилал</u>	Нөлөө их
<p>Бодит байдал: 2023 оны жилийн эцсийн санхүүгийн тайлан баталгаажуулах аудитаар Төрийн аудитын газраас дээрх зөрчилд албан шаардлага өгсөн. 2024 онд уг алдаа зөрчлийг залруулахгүй, давтан гаргасан байна. 2024 онд 52,756,9 мянган төгрөгийн шууд худалдан авалт хийхээр “Тэс петролиум” ХХК-тай гэрээ байгуулсан, 108,000.0 мянган төгрөгийн нүүрсний худалдан авалт, 63,500.0 төгрөгийн сэлбэг материал худалдан авах зэрэгт худалдан авах ажиллагааг зохион байгуулаагүй байна. 2023 оны жилийн эцсийн санхүүгийн тайлан баталгаажуулах аудитаар Төрийн аудитын газраас дээрх зөрчилд албан шаардлага өгсөн. 2024 онд уг алдаа зөрчлийг залруулахгүй, давтан гаргасан байна.</p>	
<p>Байх ёстой шаардлага /шалгуур/: ТБОНӨХБАҮХАТ Хуулийн 6 дугаар зүйлийн 6.1-дэх “Худалдан авах ажиллагаанд ил тод, өрсөлдөх тэгш боломжтой байх зарчмыг баримтална” 8 дугаар зүйлийн 8.4-т “Тендер шалгаруулалтын журмыг сонгохдоо тухайн бараа, ажил, үйлчилгээний нийт төсөвт өртгийг үндэслэл болгоно”, 31 дүгээр зүйлийн 31.1. дэх “Захиалагч ерөнхий гэрээний аргаар худалдан авахаас бусад тохиолдолд хуульд заасан төсөвт өртөгт үндэслэн тендер шалгаруулалтын дараах аргын аль нэгийн дагуу зохион байгуулна.”, 31.1.2. дэх “харьцуулалт;”, Засгийн газрын 2024 оны 02 дугаар тогтоолын 1 дүгээр хавсралт “Шууд худалдан авч болох төсөвт өртгийн дээд хязгаар бараа -20 сая төгрөг, ажил -20 сая төгрөг”</p>	
<p>Асуудлын үндсэн шалтгаан: Худалдан авах ажиллагааны талаар хууль эрх зүйн мэдлэг дутмаг</p>	
<p>Байгууллагад үзүүлэх нөлөө /үр дагавар/: Хууль тогтоомжийн хэрэгжилтийг хангаагүй бусдад давуу байдал үзүүлсэн, зөрчлийг залруулахгүй давтан гаргаж байгаа нь байгууллагын удирдлага, удирдлагын багийн санхүүгийн сахилга бат хангалтгүй, ашиг сонирхлын зөрчилтэй мэт харагдаж байна.</p>	
<p>Шийдвэр: Цаашид худалдан авах ажиллагааг хууль тогтоомжид заасан тендер шалгаруулалтын аргыг сонгохдоо босго үнийг баримталж ажиллуулах зорилгоор зөрчлийг таслан зогсоох, дахин давтан гаргахгүй байх албан шаардлага хүргүүлэхээр шийдвэрлэв.</p>	

4.7 Цэвэр, бохир ус, дулаанаар хангагч болон хэрэглэгчийн хооронд байгуулсан гэрээний хэрэгжилт.

<u>Илэрсэн асуудал 12</u>	Цэвэр, бохир ус, дулаанаар хангагч болон хэрэглэгчийн хооронд байгуулсан гэрээний сунгалтгүй, хэрэгжилтийг дүгнээгүй байна
<u>Асуудлын ангилал</u>	Нөлөө дунд

Бодит байдал:

Тус сумын хэмжээнд цэвэр бохир усны үйлчилгээг 130 аж ахуйн нэгж байгууллага, 1306 өрхөд үзүүлдэг. Ихэнх аж ахуйн нэгж байгууллагууд тоолууртай, айл өрхүүд тоолуургүй учраас ам бүлийн тоогоор төлбөрөө төлдөг.

Тулган баталгаажуулахад: оршин суугчтай байгуулсан гэрээний хугацаа 2022.12.31-нд дууссан, ам бүлийн тоо бичээгүй болон огт бичилт хийгдээгүй 47, ААН Байгууллагатай хийсэн гэрээний хугацаа 2023.12.31-нд дууссан боловч сунгалтын 2025.01.03-наас гэж урьдчилж хийсэн, суурь хураамжийг автоматаар тавьсан байна.

Оршин суугчтай байгуулсан гэрээ 496, ААН Байгууллагатай хийсэн гэрээ-131, нийт 629 гэрээ ирсэн. 1 ам бүлтэй -102, 2 ам бүлтэй -149, 3 ам бүлтэй -100, 4 ам бүлтэй -68, 5 ам бүлтэй -22, 6 ам бүлтэй -8 байлаа.

Байх ёстой шаардлага /шалгуур/:

Хот, суурины ус хангамж, ариутгах татуургын ашиглалтын тухай хуулийн 20.1.Хэрэглэгчийн хэрэглэсэн цэвэр усны хэмжээг энэ хуулийн 13 дугаар зүйлд заасны дагуу байгуулсан гэрээ, эрх бүхий байгууллагаар баталгаажсан усны тоолуурын заалтыг үндэслэн тооцно. 20.2 Усны тоолуургүй хэрэглэгчийн хэрэглэсэн унд, ахуйн ус, хэрэглээнээс гарсан бохир усны хэмжээг байгаль орчин, хот, суурины ус хангамж, ариутгах татуургын асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагаас тогтоосон хэрэглээний жишиг, нормыг үндэслэн тодорхойлно.

Асуудлын үндсэн шалтгаан:

Тус газрын борлуулалтын ажилтан болон удирдах албан тушаалтан нар цэвэр усаар хангах, бохир ус татан зайлуулах гэрээний сунгалтыг шинэчилдэггүй гарын үсэг, тамга тэмдгээр баталгаажуулдаггүй. Гэрээний хэрэгжилтийг дүгнэдэггүй.

Байгууллагад үзүүлэх нөлөө /үр дагавар/:

Цэвэр, бохир ус, дулаанаар хангагч болон хэрэглэгчийн хооронд байгуулсан гэрээний сунгалтгүй, хэрэгжилтийг дүгнээгүйн улмаас хэрэглэгч хэрэглээний төлбөрөө төлөхгүй байх эрсдэл үүснэ. Авлага хуримтлагдана.

Шийдвэр:

Цаашид борлуулалтын ажилтан нь тайлант хугацаа бүрд гэрээг шинэчлэн баталгаажуулж, дүгнэж, нягтлан бодогчтой тооцоо нийлсэн актыг сар бүр хийж байх зөвлөмж хүргүүлэхээр шийдвэрлэв.

Илэрсэн асуудал 13

Цэвэр бохир усны үнэ тарифыг ижил төстэй үйл ажиллагаа эрхэлдэг байгууллагатай харьцуулахад хямд байгаа нь үйлдвэрлэлийн ашигт ажиллагаанд сөргөөр нөлөөлж байна.

Асуудлын ангилал

Нөлөө их

Бодит байдал:

Инженерийн шугам сүлжээ нь 40 жилийн насжилттай дээрх хугацаанд бүрэн хэмжээний шугам сүлжээний шинэчлэлт хийгдээгүй улмаас цэвэр бохирын шугамын засварын ажилд ихээхэн хэмжээний зардал гардаг, цэвэр ус дамжуулах өргөх станц нь 18.9 км-н зайнаас усаа татдаг тул түүнийг дагаад цахилгаан хэрэглээний төлбөр өндөр гарч байгаа, айл, өрх, албан байгууллагууд хэрэглээний төлбөрөөр олон сар жилээр төлөөгүй байгаа зэрэг нь үйлдвэрлэлийн үйл ажиллагаанд сөргөөр нөлөөлж байна. Мөн цэвэр бохир усны үнэ тариф нь бусад ижил төстэй үйл ажиллагаа эрхэлдэг байгууллагаас хямд байгаа нь үйлдвэрлэлийн зардлыг нөхөж хүрэлцэхгүй байна.

Байх ёстой шаардлага /шалгуур/:

Хот, суурины ус хангамж, ариутгах татуургын ашиглалтын тухай хуулийн 10 дугаар зүйлийн 10.1.1 дэх “цэвэр, бохир усны үйлчилгээний тарифын бүтцийг тодорхойлох, тариф тогтоох аргачлал, төлбөр тооцох журам, цэвэр, бохир усны үйлчилгээний тарифыг хянаж батлах, нийтлэх, индексжүүлэлтийг хэрэгжүүлэх” 14 дүгээр зүйлийн 14.2.6 “үйлчилгээний тарифын хэмжээ тогтоох саналыг боловсруулж, Зохицуулах хороогоор батлуулж, мөрдөх”

Асуудлын үндсэн шалтгаан:

Ижил төстэй үйл ажиллагаа эрхэлдэг аж ахуйн нэгж байгууллагын үнэ тарифыг судалгаа хийж өөрийн үнэ тарифыг нэмэгдүүлэх саналаа боловсруулж холбогдох дээд шатны байгууллагад уламжилж шийдвэрлүүлээгүй.

Байгууллагад үзүүлэх нөлөө /үр дагавар/:

Тус газрын үйл ажиллагаанд мөрдөгдөж байгаа цэвэр усаар хангах, бохир ус татан зайлуулах үйлчилгээний хөлс нь ижил төстэй үйл ажиллагаа эрхэлдэг байгууллагын үнэ тарифтай харьцуулахад цэвэр ус айл өрхөд м³ нь 0.44-0.50 төгрөг, аж ахуйн нэгж байгууллагад 1.20 төгрөгөөр хямд, бохир ус татан зайлуулах нь айл өрхөд м³ нь 0.62-0.70 төгрөг, аж ахуйн нэгжид 2.70 төгрөгөөр хямд байгаа нь алдагдал хүлээх шалтгаан болж байна.

Шийдвэр:

Гадаад орчны судалгаа хийж тул цэвэр бохир усны үнэ тарифыг нэмэгдүүлэх саналаа боловсруулж зохицуулах хороонд хүргүүлж шинэчлэн тогтоох **Зөвлөмж** хүргүүлэхээр шийдвэрлэв.

5.НЭГДСЭН ДҮГНЭЛТ

“Гавшгай-Ус” ААТҮГ -ын ажлын байрны чиг үүргийн нягтруулж бүтцийг оновчтой болгох замаар бүтэц, орон тооны дээд хязгаарыг аймгийн Засаг даргаар шинэчлэн батлуулж ажиллах.

Он дамжсан 1,910,085.9 мянган төгрөгийн авлагыг барагдуулах ажлын хэсэг байгуулан тусгайлсан төлөвлөгөө, авлага барагдуулах урамшуулал системийг боловсруулан үр дүн гарган ажиллах.

Борлуулалтын орлого хариуцсан байцаагч нарын ажлын гүйцэтгэл, үр дүнд суурилсан цалингийн тогтолцоог бий болгон ажиллах.

Хөтөл Энержи ХХК-д түрээсээр ашиглуулж байгаа Үндсэн хөрөнгийн бүртгэлд 1985 онд ашиглалтад орсон 12 км дулааны шугам сүлжээ нь өөрийн байгууллагын үйл ажиллагаанд үр ашиггүй, үйлдвэрийн зардлыг нэмэгдүүлж байгаа тул зах зээлийн бодит үнэ цэнийг тогтоон харилцан тохиролцож худалдан өмчлөгчийн эрхийг ашиглагч байгууллагад хууль тогтоомжийн хүрээнд шилжүүлэх.

Хэрэв дээрх асуудлыг харилцан тохиролцож шийдвэрлэж чадахгүй тохиолдолд өөрсдөө дулаан үйлдвэрлэх, ханган нийлүүлэх үйл ажиллагааг бие даан явуулж орлогын эх үүсвэрийг нэмэгдүүлэх бодлогын шийдвэр гаргах хувилбарыг тус тус боловсруулан аймгийн ИТХ-д танилцуулан шийдвэрлүүлэх арга хэмжээг авч цаашид гарах үр ашиггүй эдийн засгийн ач холбогдол багатай жилээс жилд санхүүгийн эрсдэлийг нэмэгдүүлж байгаа тулгамдсан асуудлыг яаралтай шийдвэрлүүлэх нь зүйтэй юм.

жилээс жилд санхүүгийн эрсдэлийг нэмэгдүүлж байгаа тулгамдсан асуудлыг яаралтай шийдвэрлүүлэх нь зүйтэй юм.

Дээрх дүгнэлтүүдийг үндэслэн газрын 2023-2024 оны үйл ажиллагаанд хийсэн дотоод аудитын хүрээнд байгууллагын засаглал, санхүүгийн үйл ажиллагаанд хууль, тогтоомж, дүрэм журмыг хэрэгжүүлдэггүй. Санхүүгийн сахилга бат муу, борлуулалтын орлогын программ нь шаардлага хангахгүй, он дамнасан өр төлбөр, авлага барагдуулах тал дээр бодитой ажил, арга хэмжээ авч хэрэгжүүлээгүй, худалдан авах ажиллагааг хуулийн дагуу зохион байгуулдаггүй зэрэг алдаа зөрчлийг үндэслэн “Хангалтгүй” гэсэн дүгнэлтийг өгч байна.

Дүгнэлтийн төрөл	Дүгнэлтийн тайлбар
Хангалтгүй	Засаглал эрсдэлийн удирдлага болон дотоод хяналтын үйл явцын төлөвшил нь “эхлэлийн буюу 1-р түвшин”-д байна гэж үзсэн. Аудитаар илэрсэн асуудлуудын 80%-иас дээш нь “нөлөө ихтэй” гэж үзсэн.

ТАЙЛАН БЭЛТГЭСЭН:

ДОТООД АУДИТОР

Г.ДОРЖДЭРЭМ

ДОТООД АУДИТОР

Х.БАТБААТАР

ТАЙЛАН ХЯНАСАН

ДАРГА

Т.ОДСҮРЭН

ТАНИЛЦСАН:

САЙХАН СУМЫН “ГАВШГАЙ-УС” ААТҮГ-Н

ГАЗРЫН ЗАХИРАЛ

Б.ҮҮРДМӨНХ

ЕРӨНХИЙ НЯГТЛАН БОДОГЧ:

Д.АДЪЯАСҮРЭН

ТООЦООНЫ НЯГТЛАН БОДОГЧ:

Д.ОЮУНЧИМЭГ